



UB METRO

**УЛААНБААТАР  
МЕТРО ТӨСӨЛ**



## 1. ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;

**9.3.12.** "Олон төрөлт, ухаалаг нийтийн тээврийг хэрэглээнд нэвтрүүлнэ".

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөр;

**4.1.3.** "Нийтийн тээврийн чанар, стандартыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх багтаамж ихтэй нийтийн тээврийн шинэ технологи нэвтрүүлэх".

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр";

**1.1.5.3.** "Толгойтоос Амгалан хүртэл Энхтайваны өргөн чөлөө дагуу 17.7 км "Их багтаамжийн нийтийн тээвэр Метро шугам-1", Ард Аюушийн өргөн чөлөө-Их тойруу-Намъянжүгийн гудамж-Нийслэл хүрээ өргөн чөлөө дагуу 11.9 км урт тусгай замын автобус "BRT Шугам-1", Яармагаас Хархорин хүртэл Туул гол дээгүүр 4.2 км урт "Дүүжин тээвэр шугам-1" бүхий олон төрөлт их багтаамжийн нийтийн тээврийн системүүдийн уялдаа холбоог хангаж, зорчигч тээврийн логистик төвийн хамт үе шаттайгаар барьж байгуулна".

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 24/08 дугаар тогтоол, 2025 оны 25/111 дүгээр тогтоолоор батлагдсан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр;

**1.** "Толгойтоос Амгалан хүртэл Энхтайваны өргөн чөлөө дагуу 19.4 км урт Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро" төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ".

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны Нийслэл Улаанбаатар хотод Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро" байгуулах тухай 411, 484 дүгээр тогтоол;  
Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 46 дугаар хурлын тэмдэглэл.

## 2. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ, ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ



*УБ Метроны чигийн төлөвлөлт*

Нийтийн тээврийн чанар, стандартыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилт, арга хэмжээний хүрээнд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод үндэсний онцлог, хэв шинж, нийслэлийн иргэдийн язгуур эрх ашигт нийцсэн, олон улсын стандарт, шаардлагыг бүрэн хангасан Их багтаамжын нийтийн тээврийн хэрэгсэл “Метро”-г барьж байгуулах төслийг 2024~2030 онд багтаан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Төлөвлөж буй тус төсөл нь Толгойтоос Амгалан чиглэлд 19.4 км урт шугамтай, 15 өртөөтэй бөгөөд алслагдсан дүүргүүдийг хотын төвтэй холбосноор хотын доторх болон дагуул бүсүүдийн хөгжлийг жигд хангах боломжийг бүрдүүлэх бөгөөд хотын захын оршин суугчид нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, бүс нутгийн ялгааг багасгах ач холбогдолтой.

Мөн 15 өртөөний орц болон гарц, тухайн өртөө орчмыг ирээдүйн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан өргөжин хөгжих боломжтой байдлаар төлөвлөж байна. Ингэснээр 15 өртөө бүр худалдаа, үйлчилгээ, авто зогсоол төвлөрсөн дэд төвүүд болж хөгжих бөгөөд УБ хотыг нэг төвт хотоос олон төвт болгон өргөжүүлэх, мөн дагуул хотууд болон бусад хотуудтай найдвартай тээврээр холбох холбоос HUB болно.

*Их дэлгүүр ба ASA Arena хоорондын W1 өртөөг дамжин өнгөрөх газар доорх холболт*





## Техникийн үзүүлэлт

Нийслэл Улаанбаатар хотын нийтийн тээврийн чанар, үйлчилгээ, стандартыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар түгжрэлийг бууруулахад ач холбогдол бүхий “Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл Метро” төслийн техникийн үзүүлэлт:

**17,200** НИЙТ ХУЧИН  
ЧАДАЛ  
ХУН/ЦАГ/ЧИГЛЭЛ

**19.4** МЕТРОНЫ ТРАССЫН  
НИЙТ УРТ, КМ

**15** НИЙТ  
ӨРТӨӨНИЙ ТОО

Техникийн хурд: **100 км/ц** (туннелд **80 км/ц**)

Туулах хугацаа: **31.25** минут

Оргил цагийн интервал: **4.5~5.0** минут тутам

### ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН

Галт тэрэгний тоо: **6** вагонтой **19** галт тэрэг

Нийт вагоны тоо: **114** вагон

Цариг: **1435** мм

Автоматжуулалтын түвшин: **GoA 3-4**

### БАЙГУУЛАМЖ

Депоны талбай: **26.6** га

Өртөөний хэмжээ: **170×25×20м(3 давхар)**

Эрчим хүчний чадлын дээд шаардлага: **29МВт**

### ТУННЕЛИЙН БАЙГУУЛАМЖ БА УХАХ АРГАЧЛАЛ

Газрын гүнд суух түвшин: **(-10)м~(-25)м**

Туннелийн диаметр: **D=6.6-7.3м**

Туннелийн нийт урт: **19.1 км**

TBM аргаар ухах туннелийн урт: **15.3 км**

Ухах & буцааж булах (өртөө орчмын хэсгүүд): **3.5 км**

Ил ухах: **0.14 км** Газрын түвшинд: **0.25 км**



Оргил цагийн нэг чиглэлийн ачаалал (PHPDT):

**2030 онд: 15,526 зорчигч/цаг**

**2040 онд: 17,206 зорчигч/цаг**

Өдрийн нийт зорчигч урсгал

**2030 онд: 464,649 зорчигч/өдөр**


**2040 онд: 559,132 зорчигч/өдөр**

Улаанбаатар хотын хэмжээнд замын хөдөлгөөний эрчим-нэвтрүүлэх чадварын харьцаа (**V/C ratio**) дунджаар **2.1 ээс 1.39** болж буурна.

Замын хөдөлгөөний дундаж хурдыг **18** хүртэлх хувиар нэмэгдүүлэх эерэг үр нөлөөтэй.



УБ Метроны чигийн төлөвлөлт





### 3. ТӨСЛИЙН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ

Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро”-г барих төслийн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр Бүгд Найрамдах Солонгос Улсын Dohwa Engineering Co.Ltd-ын ахалсан түншлэл шалгарч, 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдөр “Улаанбаатар метро” төслийн зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулсан. Төслийн менежментийн зөвлөх баг нь 2013 онд Жайка олон улсын байгууллагаас боловсруулагдаж байсан урьдчилсан ТЭЗҮ-г шинэчлэн боловсруулах, төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ болон төслийн Захиалагчийн хяналтын үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

Шинэчилсэн техник эдийн засгийн үндэслэл нь хот төлөвлөлтийн олон улсын чиг хандлага, хотын тээврийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, газар доорх орон зайн ашиглах, байгаль орчин, нийгэм эдийн засгийн хөгжлийг дэмжин уялдаа холбоог хангаж Улаанбаатар метро төслийн холбогдох бүх асуудлыг цогцоор нь тусгаж, үндэслэлтэй шийдвэр гаргах, төслийг амжилттай хэрэгжүүлэх үндэс суурь болох төлөвлөлтийн баримт бичиг болсон.

Төлөвлөлтийн суурь судалгаа	Төслийн үндсэн концепц ба нийгэм, эдийн засаг, байгаль орчны судалгаа Төлөвлөлтийн суурь судалгаа
Инженер Геологи судалгаа (42 байршилд өрөмдлөг)	Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ
Геодези байр зүйн судалгаа	Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ
Гидрогеологийн судалгаа	Хууль эрх зүйн орчны судалгаа
Технологийн шийдлийн судалгаа	Нийгэм эдийн засгийн судалгаа
Материалын судалгаа	Төсвийн зардал, үр ашгийн тооцоолол
Тээврийн эрэлтийн судалгаа	Төслийн үйл ажиллагаа, менежментийн төлөвлөлт
Замын дэд бүтэц	Төслийн концепц
Өртөөний байгууламж, Нийтийн	Чигийн төлөвлөлт
Тээвэрт Суурилсан Хөгжүүлэлт (TOD)	Хөдлөх бүрэлдэхүүн
	Байгууламжийн төлөвлөлт
	Бүтээцийн төлөвлөлт
	Цахилгаан хангамж, холбоо дохиолол
	Механикийн төлөвлөлт
	Ашиглалт, засвар үйлчилгээ
	Эрсдлийн үнэлгээ, менежментийн төлөвлөгөө



ТЭЗҮ шинэчлэн боловсруулах олон улсын баг нь Төслийн удирдлагын баг, Хотын тээвэр төлөвлөлтийн баг, Эдийн засаг, санхүүгийн шинжилгээний баг, Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний баг, Инженер, техникийн зураг төслийн баг, Эрсдэлийн менежмент ба эрсдэлийг бууруулах баг, Оролцогч талуудын оролцоо ба харилцаа холбооны баг болон бусад холбогдох байгууллагын зөвлөх багийхан хамтран ажиллаж амжилттэй батлуулсан.

2025 оны 03-р сарын 25-нд НИТХ-н V хуралдаанаар хэлэлцүүлж дэмжигдсэн.

- Зам, тээврийн яамны дэргэдэх холбогдох дэд зөвлөл, Шинжлэх ухаан, техникийн зөвлөлөөр хэлэлцүүлэн дэмжигдсэн. Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны Барилгын хөгжлийн төвийн экспертийн баг Нийслэл Улаанбаатар хотод Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “МЕТРО” барьж байгуулах төслийн техник эдийн засгийн үндэслэлд 2025 оны 03 дугаар сарын 14-ны өдөр магадлал хийж баталгаажуулсан.

## Төслийн Байгаль Орчин, Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээ (БОННУ)

Улаанбаатар метро төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ) боловсруулах ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс Төслийн менежментийн зөвлөх “Духуа Инженеринг” ХК болон түүний туслан гүйцэтгэгч “ЭКО НАТУР” ХХК хамтран эхлүүлсэн. Ажлын хүрээнд эхний тайланг 2025 оны 07 дугаар сард, дундын тайланг 09 дүгээр сард тус тус боловсруулж, эцсийн тайланг 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдөр бэлэн болгон БОУАӨЯ-ны цахим мэдээллийн санд баримт бичгийн бүрдлийг ханган байршуулсан. Төслийн БОННУ эцэслэгдэж БОУАӨЯ-ны мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2025 оны 12-р сарын 16-ны өдөр хэлэлцүүлэгдэж засвар орхоор дэмжигдсэн. Тус хурлаар гаргасан санал зөвлөмжийн дагуу засвар оруулж 2026 оны 1-р сарын 9-ний өдөр батлагдсан.



Цахим хангагч: <https://ec.mn/en/impact/more.php?reportId=9543>



Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний таван жилийн нийт зардал 1,811,644,841 (нэг тэрбум найман зуун арван нэгэн сая зургаан зуун дөчин дөрвөн мянга найман зуун дөчин нэг) төгрөгийг төслийн ерөнхий гүйцэтгэгч хариуцна.

- Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал: 63,760,000 төгрөг.
- Биологийн олон янз байдлыг хамгаалах, дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний зардал: 1,536,731,841 төгрөг.
- Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний зардал: 114,013,000 төгрөг.
- Нийгэм шийдвэрлэлтийн зардал: Үйл ажиллагааны зардалд тусгасан
- Түүх, соёлын өвийг хамгаалах зардал: Үйл ажиллагааны зардалд тусгасан
- Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал: Үйл ажиллагааны зардалд тусгасан
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал: 51,940,000 төгрөг.
- Тухайн жилийн БОМТ, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдох талуудтай тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь, төсвийн зардал: 5,200,000 төгрөг.
- 2 жил тутамд аудит хийх зардал: 40,000,000 төгрөг.



## Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн иж бүрэн үнэлгээ (Олон улсын)



Төслийн хүрээнд олон улсын стандартын дагуу Төслийн менежментийн зөвлөх “Духуа Инженеринг” ХК болон түүний туслан гүйцэтгэгч болох олон улсын экспертүүдээс бүрдсэн “Inogen Alliance” байгууллага нь Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн иж бүрэн үнэлгээ (Full ESIA) болон Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (ESMP)-г олон улсын санхүүжүүлэгч байгууллагуудын шаардлагуудад (IFC, EP4, OECD) нийцсэн байдлаар 2025 оны 11 дүгээр сарын 28-нд боловсруулж дууссан.



*Чингэлтэй дүүргийн 1, 2, 3 дугаар хороодын иргэдэд танилцуулах, санал солилцох уулзалтыг 2025 оны 06 дугаар сарын 25-нд зохион байгууллаа.*





## 4. ТӨСЛИЙН ЯВЦ

Сүсөнг Инженеринг,  
БНСУ  
Улаанбаатар хотын  
метро төслийн ТЭЗҮ

ЖАЙКА, Япон улс  
Улаанбаатар хотод  
нийтийн тээврийн  
төслийн хэрэгжих  
судалгаа  
Улаанбаатар метро  
төслийн ТЭЗҮ

2011

2013

ТЭЗҮ & концепц  
зураг төсөл  
батлагдсан

ТЭЗҮ & концепц  
зураг төсөл  
БОЛОВСРУУЛСАН

2025

3 сарын 14

2024 -8 сар-  
2025 -1 сар

В банкинд (RFP)  
хүргүүлсэн  
/Зохицуулагч банк/  
Сонгон шалгаруулалт  
зарласан

2025

3 сарын 18

Нийслэлийн  
Иргэдийн  
Төлөөлөгчдийн  
Хурлаар (НИТХ) ТЭЗҮ  
дэмжигдсэн

Зохицуулагч банк  
/Arranger bank/  
Сонгон  
шалгаруулалтын  
үр дүн зарласан

2025

3 сарын 25

2025

4 сар

Ашиглалт, засвар  
үйлчилгээ (институт  
байгуулах)  
Зүгшрүүлэх  
ажиллагаа эхлүүлэх

Бүтээн байгуулалтын  
хугацаа 60~ сар

2031

9 сар

УЛААНБААТАР  
МЕТРО  
Ашиглалтад оруулах

2031

12 сар

Засгийн газар 411,  
484 дүгээр тогтоол  
Их багтаамжийн  
нийтийн тээврийн  
хэрэгсэл “Метро”-г  
барьж байгуулах  
тухай

Төслийн менежментийн  
зөвлөх үйлчилгээ, (PMC)  
Сонгон шалгаруулалт  
явагдаж  
11 улсын 20 компани  
оролцсон



2023

2024  
2-7 сар

ЕРС гүйцэтгэгч (FIDIC  
Silver Book)  
Үе шат 01 | Сонирхол  
илэрхийлэх хүсэлт  
Тендер зарлагдсан  
(tender.gov.mn)  
Олон улсын порталд  
нийтэлсэн (2024.10.08)

Улаанбаатар метро  
хүний нөөц бэлтгэх  
Санамж бичиг  
байгуулсан  
НЭДТГ, ШУТИС, РМС

(PMC) Төслийн  
менежментийн  
зөвлөх үйлчилгээ  
DOHWA Engineering  
ХК-иар ахлуулсан  
түншлэлтэй гэрээ  
байгуулсан.

2024  
10 сар

2024  
9 сар

I үе шат | Сонирхол  
илэрхийлэх хүсэлт  
тендерийн нээлт  
(27 компани сонирхол  
илэрхийлсэн)

Улаанбаатар метро  
хүний нөөц бэлтгэх 2+2  
хөтөлбөр  
Анхны элсэлт (ШУТИС)  
50+ оюутан элссэн

2025  
6 сар

2025  
9 сар

Гэрээ байгуулах,  
ажил эхлүүлэх  
Бэлтгэл үе шат,  
захиалагч (хамгийн  
өндөр үнэлгээтэй  
оролцогчийг сонгох,  
санхүүжилтийн  
хэлэлцээр хийгдэх)

II үе шат | ЕРС  
гүйцэтгэгч  
Тендер сонгон  
шалгаруулалт

II үе шат | ЕРС  
гүйцэтгэгч  
ТЕНДЕР ЗАРЛАСАН  
Багц I-г ЕРС+F  
нөхцөлөөр  
зарласан

2026  
8 сар

2026  
7 сар

2025  
12 сар

Төслийн менежментийн зөвлөх “Духуа Инженеринг” ХК болон түүний түншлэл тендерт шалгаран гэрээ байгуулсан цагаас хойш төслийн ТЭЗҮ, эх загвар зураг болон бусад холбогдох баримт бичгүүдийг шинэчлэн боловсруулж НИТХ дэмжиж батлуулсан. БОННУ Тайланг батлуулсан. Төслийн ерөнхий гүйцэтгэгч компани сонгон шалгаруулах тендерийн 1-р шатанд сонирхлоо илэрхийлсэн 6 улсын 27 компани дунд тендерийн 2-р шатны үр дүнг 2026 оны 07 дугаар сарын 03-нд нээхээр ажиллаж байна.

### Хот байгуулалт

Улаанбаатар хотын төвөөр явах метроны төсөл нь Улаанбаатар хотын 2040 оны Хөгжлийн Ерөнхий төлөвлөгөө (**УБХЕТ 2040**) - нд тутгагдсан 14 хотын төв дундаас 7 төвийг дайран өнгөрөх нь хотын орон зайн бүтэц, тээврийн сүлжээнд стратегийн томоохон өөрчлөлт авчрах ач холбогдолтой.

Метроны нөлөөллөөр хотын хэвтээ тэнхлэгийн гол гудамж зам болох Энхтайваны өргөн чөлөө дагуух хот байгуулалт, газар ашиглалт, барилгажилтын чиг хандлага эрс шинэ шатанд шилжинэ. Ялангуяа өндөр нягтралтай, нийтийн тээврийг түшиглэсэн хөгжлийн загвар бодитоор хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

Метроны өртөө орчмын бүсүүдэд **“20 минутын хот”**-ын үзэл баримтлал хэрэгжих бөгөөд оршин суугчид өдөр тутмын хэрэгцээт үйлчилгээний төвүүдэд богино хугацаанд, саадгүй хүрэх боломжтой болно. Иргэдэд амьдрахад таатай, нийгэм-эдийн засгийн идэвх оролцоог нэмэгдүүлэх чухал хүчин зүйл болно.

Метроны өртөө орчмын нийт **1,318 га** талбайг тээвэрт суурилсан хөгжүүлэлтийн (TOD) зарчмаар дахин төлөвлөснөөр хотын орон зайн бүтэц илүү оновчтой болж, эдийн засгийн идэвхжил нэмэгдэх боломж бүрдэнэ. Үүний үр дүнд 2031 оноос эхлэн жил бүр дунджаар **71.99 сая ам.долларын** хөрөнгө эргэлтэд орох урьдчилсан тооцоо гарч байна.

Түүнчлэн зөвхөн тээврийн дэд бүтцийг сайжруулахаас гадна хотын өнгө үзэмж, төрх, хөгжлийн чиг хандлагыг шинэ түвшинд гаргах, илүү хүртээмжтэй, тогтвортой, өрсөлдөх чадвартай хот болгон хөгжүүлэх чухал шийдэл юм.





## Тээврийн зардлын хэмнэлт ба Эдийн засгийн үр ашиг

Метро төсөл замын түгжрэлийг бууруулж, зорчих үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

- Зорчих хугацааны зардал (ТТС) жилд **281.6 сая ам.доллараар** буурна.
- Тээврийн хэрэгслийн ашиглалтын зардал (VOC) жилд **347.6 сая ам.доллараар** буурна.
- Зам тээврийн ослоос үүдэлтэй зардал жилд 3.3 сая ам.доллараар буурна.
- НӨАТ-ын орлого жилд **117.0 сая ам.доллараар** өснө.
- ХХОАТ-ын орлого жилд **52.3 сая ам.доллараар** өснө.
- Үл хөдлөх хөрөнгийн татварын орлого жилд **86.4 сая ам.доллараар** нэмэгдэнэ.
- ААНОАТ-ын орлого жилд **52.3 сая ам.доллараар** нэмэгдэнэ.

## Байгаль орчны үр өгөөж

Метро хувийн автомашины хэрэглээг эрс бууруулах замаар агаар орчны бохирдлыг бууруулах, хүлэмжийн хийн ялгарлыг багасгахад чухал үүрэгтэй.

- **CO<sub>2</sub>** ялгаралт жилд **213,600** тонноор буурна.
- Азотын исэл (**NOx**) ялгаралт жилд **400** тонноор буурна.
- **SOx** жилд **7%**-иар буурна;
- Мөнгөн дүнгээр тооцвол жилд **13.1 сая ам. долларын** хэмнэлт юм.



## Нийгэм, эдийн засаг

- 2040 оноос эхлэн түгжрэл, алдагдсан цаг хугацааны өртөг буурч, жил бүр **~632.5 сая ам.долларын** эдийн засгийн хэмнэлт хийнэ.
- Замд зарцуулах хугацаа багассанаар аж ахуйн нэгжүүдийн бүтээмж өсөж, иргэдийн чөлөөт цаг, хувь хүний хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ.
- Хотын аялал жуулчлал хөгжиж, улсын эдийн засагт эерэг үр өгөөж бий болно.
- НӨАТ, ХХОАТ, үл хөдлөх хөрөнгийн татвар, ААНОАТ-ын орлого жил бүр **~308 сая ам.доллараар** нэмэгдэнэ.

Иргэд автобусаар 143 минутад явах зайг метрогоор 31.25 минутад туулах нөхцөл бүрдээд зогсохгүй нийт өртөөнүүдийн хэмжээнд **150~200** жижиг, дунд бизнес эрхлэгч шууд үр ашгийг хүртэх боломж бүрдэхээр байна. Төсөл хэрэгжсэнээр ойролцоогоор **~150,000 ажлын байр 15 өртөө орчимд жигд төвлөрнө**. Мөн энэхүү төсөл нь тусгай хэрэгцээт иргэдийн хэрэгцээнд бүрэн нийцсэн орц, гарц бүхий тав тухтай тээврийн хэрэгсэл байх юм.

Эцэст нь, метро төсөл нь зөвхөн дэд бүтцийн хөгжил бус, хотын түгжрэл, тээврийн зардал, агаарын бохирдлыг бууруулах бодит шийдэл бөгөөд нийтийн тээврийн найдвартай ажиллагаа, дэд бүтцийн ашиглалт сайжрах, хотын тээврийн цогц систем бүрдэхэд бодитой дэмжлэг үзүүлнэ. Иймд энэхүү төсөл нь санхүүгийн шууд ашигт ажиллагаа харьцангуй бага боловч нийгэм, эдийн засгийн өргөн хүрээний үр өгөөжийг бий болгох, урт хугацаанд өндөр ач холбогдолтой төсөл гэж дүгнэж байна.



## 6. ОЛОН НИЙТИЙН САНАЛ ХҮСЭЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ



БОУАӨЯ-ны 12/3400 тоот бүхий ерөнхий үнэлгээний дүгнэлтийг үндэслэж “Нийслэл Улаанбаатар хотод их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл Метро барьж байгуулах” төслийн БОННУ тайланг боловсруулж дууссан ба тайлангийн хүрээнд “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журмын 1.2.2, 2.5.1, 2.5.2, 2.5.3, 2.5.4 болон 2.6-р заалтуудыг үндэслэн 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрөөс 07 дугаар сарын 03-ны өдрийн хооронд 5 дүүргийн 46 хорооны иргэдтэй 5 удаагийн хэлэлцүүлэг өрнүүлсэн.


### Нийгэм, эдийн засаг

БОННУ-ний хүрээнд нөлөөлөлд өртөж буй 5 дүүргийн 46 хорооны иргэдтэй хэлэлцүүлэг болон асуумж судалгаагаар иргэдийн 90% нь Метро барихыг дэмжиж байгаа гэж хариулсан.

Метро ашиглах хэрэгцээг дараах байдлаар тодорхойлсон байна.

**Үүнд:** • Түгжрэл ихтэй үед

- Цаг хугацааг хэмнэхэд
- Хурд, шуурхай байдлыг эрхэмлэх үед
- Яарсан, яаралтай нөхцөл байдалд
- Дугаарын хязгаарлалттай, автомашин хэрэглэх боломжгүй өдрүүдэд
- Ажил, албан үүргээ цагт нь гүйцэтгэхэд
- Өдөр тутамд
- Танин мэдэх, сонирхон ажиглах хүсэлтэй үед
- Бусад хэрэгцээнд (гэртээ харих, хүүхдээ хүргэх, чиглэлээ тохируулах гэх мэт)



Метро ашиглахгүй гэж өгсөн саналуудын шалтгаанууд

### Асуумж судалгааны дүгнэлт:

Иргэд метроны төслийг зөвхөн томоохон бүтээн байгуулалт гэж бус, харин өдөр тутмын амьдралд бодит өөрчлөлт авчрах шийдэл хэмээн харж байна. Тэд цаг хугацааг хэмнэх, зорчих зардлыг бууруулах, түгжрэлийг багасгах зэрэг олон талын давуу талыг онцлон, амьдралын чанарт эерэг нөлөө үзүүлэх бодит үр өгөөжийг илүүтэй хүлээж, дэмжиж байна.